

Шилжилтийн үе дэх Жендерийн асуудал

А. Солонго

Хүн Ам Зүйн Сургалт

Судалгааны Төвийн багш

1. Удиртгал

"Жендер" буюу "хүйсийн тэгш байдал" гэдэг нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн талаар тухайн нийгэмд бүрэлдэн тогтсон үзэл бодол, ойлголт бөгөөд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал, нийгэмд гүйцэтгэх үүрэг, ролиор илэрч байдаг. Жендер гэсэн нэр томъёоны нийгмийн утга нь "хүйсээр ялгаварлан гадуурхах явдал" гэсэн нэр томъёогоор голдуу илэрхийлэгддэг. "Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах" тухай Конвенцид Монгол улс 1981 онд нэгдэн орсон.

Шигтгээ 1

Монгол улсын нийт хүн амын 50,4 хувийг (1153,2 мянга) эмэгтэйчүүд эзэлж байгаагийн 54,9% нь хот суурин газарт, 45,1% нь хөдөөд амьдарч байна. Нийт эмэгтэйчүүдийн 43, 2% нь 0-15 насны охид, 47,4% нь 16-54 насны, 9,4% нь 55 ба түүнээс дээш насныхан байна. 2020 он гэхэд эмэгтэй хүн амын тоо 1730,6 мянга болох бөгөөд 0-15 насны охидын эзлэх хувь 33,9 болж буурахын сацуу хөдөлмөрийн насны болон 55-аас дээш насны эмэгтэйчүүд 54,1%, 12,0% болж тус тус нэмэгдэх ба эмэгтэйчүүдийн дундаж наслалт 62,4-67,9, эрэгтэйчүүдийн дундаж наслалт 58,5-62,5 болж өсөх төлөвтэй байна.

Түүхэн талаас нь авч үзвэл Монголын эмэгтэйчүүдийн ахуй амьдрал, тэдгээрийн нийгэмд эзлэх байр суурь XX зууны эхэн үе хүртэл олон зууны турш Дорно дахины соёлын хүрээнд оршин байсан нүүдлийн Монгол оронд харьцангуй өөрчлөлтгүй явж ирсэн гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл эртний болон дундад зууны үеийн нийгмийн тогтолцоо, хууль ёс, хөдөлмөрийн хуваарьт захирдаж, хэрэгцээ, хэрэглээ, ханамжийн онолын хүрээнд тайлбарлаж болох тийм эрх эдэлж, үүрэг хүлээж байжээ. Гэвч Манжийн колоничлолд байсан 200 гаруй жилд эмэгтэйчүүд урьдын эрх ямбаа алдсан байна. 1921 оны хувьсгалаас хойш Монголын эмэгтэйчүүд нийгмийн бүрэн эрхт гишүүн, мэргэжил боловсрол эзэмших, нийгмийн амьдралд идэвхтэй үүрэг гүйцэтгэх боломжтой тийм түвшинд хүрсэн төдийгүй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн улс төр, эдийн засгийн тэгш байдал хууль ёсоор тунхаглагдан баталгаажсан юм. 1969 он гэхэд нийт эмэгтэйчүүдийн 75,3% 1989 онд 95,7% нь ямар нэгэн боловсрол эзэмшсэн байв.

Хүснэгт 1. 10, түүнээс дээш насны хүн амын бичиг үсэг мэдэлтийн түвшин, 1963-1989

Он	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
1963	72,6	80,5	64,8
1969	82,1	88,9	75,3
1979	93,3	96,5	90,2

Үйлдвэржилт нь Монголын эмэгтэйчүүдийг үйлдвэрлэлийн процесст оролцох идэвхийг нэмэгдүүлж, эмэгтэйчүүдийн мэргэжил болон өндөр мэргэжлийн сургалтанд зориулсан нийгмийн хэрэгцээг бий болгосон юм. Хөдөлмөр эрхэлж байгаа эмэгтэйчүүд өөрсдөө орлогын тодорхой эх үүсвэр цалинтай болсноор гэр бүлийн хүрээнд тэдний байр суурь улам баталгаажлаа. 1964, 1985 онуудад эмэгтэйчүүдийг ажиллахад зохимжтой албан ажлын жагсаалтыг баталж, тодорхой хувь хэмжээ тогтоон хэрэгжүүлж иржээ. Өнөөдөр Монголын эмэгтэйчүүд эрүүл мэнд, боловсрол, соёл, худалдаа, үйлчилгээний салбарууд, уламжлалт мал аж ахуй, хөнгөн ба хүнсний үйлдвэрүүдийн ажиллах хүчний болон мэргэжилтнүүдийн дийлэнх хувийг эзэлж, эдийн засаг-нийгмийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна.

Шигтгээ 2

Манай улсад эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийн нэгэн адил иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлдэг. Тухайлбал сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалах, эд хөрөнгө эзэмших, өмчлөх, өв залгамжлах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх, эд мөнгөний тусламж авах, шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаар дамжуулан төрийг удирдах хэрэгт оролцох, ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх, төрийн байгууллага, албан тушаалтанд санал гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх халдашгүй чөлөөтэй эрхтэй.

Аливаа нийгмийн шилжилтийн үед эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн байдал дордох нийтлэг зүй тогтолтой ажээ. 1990 оноос нийгмийн шинэ харилцаанд шилжих үед гарч буй өөрчлөлтүүд эмэгтэйчүүдийн байдалд эерэг, сөрөг олон талаар нөлөөлж байна. Шилжилтийн үеийн орнуудын эмэгтэйчүүдэд тулгардаг гол бэрхшээл нь хөдөлмөрийн зах зээлээс шахагдах, нийгмийн хамгааллын асуудал орхигдох, нийгмийн харилцаа, үйл явцын өөрчлөлтөд эмэгтэйчүүд хамгийн доод түвшинд байх, эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн адил бололцоо, тэгш эрх хийсвэрлэгдэх зэргийг дурьдаж болно. Монгол орны хувьд шилжилтийн үеийг туулж байгаа бусад оронд тохиолдож буй бэрхшээлийг тойроогүй боловч монголын нийгэм, уламжлалын онцлогтой уялдсан өвөрмөц асуудлууд ч тулгарч байна. Эмэгтэйчүүдэд ардчилалд суралцах, чөлөөт сонголт хийх, өмчийн жинхэнэ эзэн болох илүү өргөн боломж нээгдлээ. Эмэгтэйчүүдийн асуудлаархи үндэсний шинэ тогтолцоо, жендерийн судалгаа, мэдээллийн албаны үндэс суурь тавигдав. Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, хөдөлгөөн өргөжин, үйл ажиллагааных нь хүрээ тэлж байна. Аж ахуйн нэгжийн эмэгтэй эзэд, хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүд, ажилгүй, ядуу эмэгтэйчүүд зэрэг өөр өөрийн онцлогтой эрх ашиг бүхий шинэ бүлгүүд нийгэмд гарч ирлээ. Ийнхүү улс төр, нийгэм, эдийн засгийн шинэ орчин нөхцөл бүрэлдэж, эмэгтэйчүүдийн өмнө шинэ шаардлага тавигдаж байна.

Монголын нийгэмд гүйцэтгэж буй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн үүргийг шилжилтийн үеийн бэрхшээл тэдэнд хэр зэрэг ялгавартай нөлөөлж байгаагаар тодорхойлж болно. Эдгээр ялгавруудыг тодорхойлох гол хүчин зүйлсийн нэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрлөх, суралцах, хуулийн өмнө хүлээх үүрэг ба нийгмийн оролцоо зэрэгт тэгш эрхийг хангаж

байсан нийгмээс шилжиж буй явдал юм. Зах зээлийн эдийн засагт шилжихэд нийгмийн үйлчилгээний салбарт ихээхэн хязгаарлалт хийх шаардлагатай болж байгаа нь нэн түрүүнд эмэгтэйчүүд, хүүхдүүдэд, өндөр настан болон нийгмийн бусад эмзэг давхаргынханд хүндээр тусч байгаад эргэлзэх аргагүй.

2. Эмэгтэйчүүд ба өрх гэр

Монгол улс "Сайн дурын үндсэн дээр гэрлэх тухай болон гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай" конвенцид 1991 онд нэгдэн орсон.

Шигтгээ 3

1996 онд 517,7 мянган өрх байгаагийн 4,4% нь ганц бие, 7,7% нь 8 ба түүнээс дээш ам бүлтэй, 15% нь 16 хүртэл насны 4 ба түүнээс хүүхэдтэй өрх, нийт өрхийн 3,5% нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх нийт өрх байв. 1989 онд 16 хүртэлх насны хүүхэдтэй гэр бүлгүй эмэгтэйчүүдийн тоо 16.5 мянга байсан бол 1996 онд 36,2 мянга буюу 2,2 дахин нэмэгдэв. Харин 16 хүрэлх насны хүүхэдтэй хань ижилгүй 5,3 мянган эцэг, хагас өнчин 57,0 мянга, бүтэн өнчин 4,1 мянган хүүхэд байна.

Захиргаадалтын үед гэрлэлтийн статус нь нийгмийн зүгээс тухайн хувь хүнийг тодорхойлох гол үзүүлэлт болж байсан бол 1990 оноос хойш үүнд төдийлэн ач холбогдол өгөхөө болжээ. Нийт сумдын 40 хувьд нь хүйсийн харьцаа их хэмжээгээр алдагдаж, хүн амын бага нягтшилтай газруудад олон гэрлэлт болон "хэцүү" хүүхдүүд олширсон ба зарим сумдад энэ хандлага өсөх төлөвтэй байна. Статистикийн баримтаас үзэхэд жилд амаржиж байгаа нийт эмэгтэйчүүдийн 12%-13% нь төрөхдөө гэрлээгүй байсан, гэмт хэрэг зөрчилд холбогдсон охид хөвгүүдийн 60 гаруй хувь нь өрх толгойлсон эхтэйгээ буюу өрөөсгөл амьдралтай гэр бүлд амьдарч байна. Хүүхдийн хаяг тогтоон шалган хуваарилах байрны 1997 оны мэдээгээр тэнэмэл хүүхдүүдийн 25: нь хагас өнчин, талаас илүү хувь нь 8-14 насны хүүхдүүд байна.

Монголд эмэгтэйчүүдийн 70 гаруй хувь нь 35 хүртэлх настай, бага насны хүүхэдтэй гэр бүл ихэсч байхад хүүхдүүдийн дөнгөж 20-оод хувь нь цэцэрлэг, яслиар хангагдаж байгаа, зардал, төлбөр зэргээс шалтгаалж хүүхдүүд эзэнгүйдэж, тэдний хүмүүжил төлөвшилд гажуудал гарахад нөлөөлж байгаа төдийгүй эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэх, мэргэжил, боловсролоо дээшлүүлэхэд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй, ажил гэрийн хооронд давхар ачаалалд дарагдаж байна. 1990 онд сругуулийн өмнөх насны хүүхдийн 1350 байгууллагад 118,8 мянган хүүхэд багачууд хүмүүжиж байсан бол 1996 онд ердөө тал нь ажиллаж, 68,0 мянган хүүхэд хамрагдаж байна. 403 ясли хаагдаж, түүнд хамрагдаж буй хүүхдийн тоо гэхэд л бараг 10 дахин буурчээ.

Хүснэгт 2. Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага, түүнд хамрагдаж буй хүүхдийн тоо, 1990-1996							
Он	1990	1991	1992	1993	1994	1995	1996
Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын тоо	1350	1297	1023	841	767	711	705
Ясли	441	414	217	118	71	51	38
Цэцэрлэг	909	883	806	723	696	660	667
Хамрагдаж буй хүүхдийн тоо (мян)	118,8	116,6	97,6	67,1	65,7	68,1	70,3
Яслид	21,6	20,9	11,9	7,2	4,7	4,0	2,3
Цэцэрлэгт	97,2	95,7	85,7	59,9	61,0	64,1	68,0

Мэдээллийн эх сурвалж: "Монгол улсын эдийн засаг, нийгэм 1996 онд", УСГ, 1997

Өрхийн түвшинд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүрэг уламжлалт байдлаа (өөрөөр хэлбэл эр хүн өрхийн гол тэжээгч байх) хадгалсаар байгаа хэдий ч эмэгтэйчүүдийн үүрэг өсөх хандлагатай болж байгааг Эмэгтэйчүүдийн мэдээлэл, судалгааны төвөөс 1997 онд явуулсан судалгааны дүн харуулж байна. Судалгаагаар эмэгтэйчүүдийн 36,0% нь өрхийн орлогын дийлэнхийг олдог, үүнээс гэрлэсэн эмэгтэйчүүдийн 33,2% нь орлогын дийлэнхийг, 25,6% нь нөхөртэйгээ тэнцүү орлого олдог гэжээ.

Эмэгтэйчүүдийн гэрийн хөдөлмөрийн үнэлгээ зохих шатанд тавигдаж чадаагүй, гэр бүлд үзүүлэх зөвөлгөө, үйлчилгээ, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын хүрэлцээ, гэрийн хөдөлмөр хөнгөвчлөх төхөөрөмжийн хангамж шаардлагаас хоцрогдсноос эмэгтэйчүүд хэт ачаалалд автагдаж байна. Гэр бүлийн амьдралд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн нөхөрсөг хамтын оролцоог хангах асуудалд анхаарч тодорхой үйл ажиллагаа явуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд 1998 онд Гэр бүлийн хуулийг шинэчлэн боловсруулахаар төлөвлөөд байна.

3. Эмэгтэйчүүд ба боловсрол

Эмэгтэйчүүдийн статусыг тодорхойлдог нийтлэг хэмжүүрийн нэг нь боловсролын янз бүрийн түвшинд тэдний эзлэх хувь юм. Боловсролтой, ажил хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүд өөрсдийнхөө чухал эрх болох эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрхээ шаардаж эдлэх чадвартай, нийгэмд өөрийгөө үнэлэх үнэлэмж өндөр, улс төрийн эрх чөлөө, ардчилалыг дэмжигчид байдаг төдийгүй хувийн болон нийгмийн амьдралдаа зөв сонголт хийж, амьдралын аливаа асуудал шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Монгол улс "Боловсролын талаар ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх" тухай НҮБ-ын конвенцид 1964 онд нэгдэн орсон.

Шигтгээ 4

Монгол улсын үндсэн хуульд зааснаар Монгол улсын иргэн бүр ерөнхий, дунд боловсролыг төлбөргүй эзэмших эрхтэй. 1995 онд шинэчлэгдэн батлагдсан "Боловсролын тухай" хуулинд "Иргэдийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох нөхцөлөөр хангана", "сурч боловсроход нь иргэдэд адил тэгш эрх эдлүүлнэ" гэж заасан.

Манай улсын насанд хүрсэн хүн амын 90 гаруй хувь нь бичиг үсэг мэддэг, 3/4 нь бүрэн бус дунд боловсролтой байгаа нь хөгжиж буй бусад улс оронтой харьцуулахад давуутай. Гэвч энэ асуудлыг анхааралтай авч үзвэл боловсролын агуулга бүхэлдээ үзэл суртал, хийсвэр бодит амьдралаас хол тасархай, зөвхөн дипломоор цалин хөлс олгодог байсан нь үр ашигтай хөдөлмөр эрхлэлтийг үгүйсгэж байв. Шилжилтийн үеийн эхний жилүүдэд Монголд хүүхдийн боловсролын асуудал хурцдах хандлага ажиглагдсан юм. 1991–1996 онд нэг хүнд ноогдох боловсролын зардал 53 хувиар буурсан нь сургуульд бүх нийтийг хамруулах, сургалтын чанарт сөрөг үр дагавар авчрав. Оюуны хөдөлмөрийн үнэлэмж бага, суралцах хэрэгцээ, идэвх чармайлт сул, сургалтын чанар доогуур байгаагийн зэрэгцээ сургууль завсардалт ихэсч, хөдөөд багш нар дутагдах болов. Өнөөдөр боловсрол хөдөөдөө илүү их хямралтай байна. Санхүүгийн эх үүсвэр муутай, багш нар дутагдалтай, салбарын цалин хөлс бага, суурин газраас алслагдсан, сургуультай хавсран ажиллах номын сан, музей байхгүй, дотуур байр цөөрч, түүний нөхцөл үйлчилгээ муудав. Тухайлбал 1994 онд л гэхэд ерөнхий боловсролын сургуулийн 1270 багш ажлаасаа гарсан бөгөөд улсын хэмжээнд 3400–аад багш хэрэгцээтэй байжээ. Сургууль завсардалт 1988–1989 онд 4% байснаа 1992–1993 онд 22% болж хамгийн эхээр өссөн буюу 48446 хүүхэд сургууль завсардсан бол 1996 онд 14272 болж буурчээ. 1989–1996 оны хооронд 166000 хүүхэд сургууль завсардсны дийлэнх нь эрэгтэй хүүхдүүд байсан бөгөөд сургууль завсардсан хүүхдүүдийн 44,9% нь МАА, үйлдвэрлэлд ажиллах шалтгаанаар суралцдаггүй байна. Нийт сургууль завсардаж байгаа хүүхдийн гуравны хоёр нь 1–4 дүгээр ангиас завсардаж байгаагийн 70% нь эрэгтэй хүүхэд байна. 1995 онд сургууль завсардсан хүүхдийн 40,6% 1996 онд 42,6% нь эмэгтэй хүүхдүүд байв. Өнөөдөр ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа өнчин сурагчдын 54,6% бүтэн өнчин сурагчдын 51,2 хувийг эмэгтэй сурагчид эзэлж байна. Гэтэл мэргэжлийн боловсролын бүх сургууль төлбөртэй болсон нь нийгмийн эмзэг энэ бүлгийнхэнд хүндээр тусч байгаа юм. Тухайлбал, хүн амын нэн ядуу өрхийн 20 хувийг чинээлэг өрхийн 20 хувьтай харьцуулахад хүүхдүүдийн бага, дунд сургуульд хамрагдалт 25 хувиар, дээд боловсролын хувьд 65 хувиар бага байна. (Хүний хөгжлийн илтгэл, Монгол, 1997)

Манайд боловсрол олгох үйл явцад хүйсээр ялгаварладаггүй ч боловсролын салбарт хүйсийн харьцаа их алдагдаж, эмэгтэйчүүд давамгайлж байгаа юм.

Хүснэгт 3. Бүх шатны сургуульд элсэгчид, төгсөгчдийн хүйсийн харьцаа		
Боловсролын түвшин	1993/1994	1994/1995
Суралцагчид	81,2	80,0
дээд боловсрол олгох ангид	49,4	48,0
Тусгай мэргэжлийн дунд боловсрол олгох ангид	31,8	29,8
Мэргэжлийн анхан шатны боловсрол олгох ангид	92,4	106,2
Ерөнхий боловсролын сургуульд	82,9	83,0
Хөдөлмөрчдийн ерөнхий боловсрол олгох ангид	109,3	106,1
Хүүхдийн цэцэрлэгт	89,5	81,5
Төгсөгчид	68,2	63,2
дээд боловсрол олгох анги	87,3	50,3
Тусгай мэргэжлийн дунд боловсрол олгох анги	44,0	27,1
Мэргэжлийн анхан шатны боловсрол олгох анги	98,0	76,6
Ерөнхий боловсролын болон ХЕБ сургууль	66,5	65,1
Үүнээс: 8-р анги	71,9	71,7
10-р анги	56,4	53,0

Мэдээллийн эх сурвалж: "Хүн ам ба хөгжил" илтгэл, 1995. ХАБХЯ

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хүйсийн харьцаа дунд, ахлах ангиас алдагдаж байгаа нь нэг талаас нийгмийн шалтгаантай, нөгөө талаас боловсролын тогтолцооноос хамаарч байна. Ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа 100 сурагчийн 54 нь, мэргэжлийн анхан, дунд боловсрол олгох ангийн 100 суралцагсдын 53 нь, дипломын дээд боловсролын ангийн 100 суралцагсдын 84 нь, бакалаврын дээд боловсрол олгох ангийн 100 суралцагсдын 68 нь, магистр, аспирантур, докторантурт суралцан цол хамгаалж байгаа 100 хүний 62 нь тус тус эмэгтэйчүүд байна. Боловсролын түвшинг насны бүлэг болон хүйсийн ялгавартайгаар авч үзвэл 20-29 насны эрэгтэйчүүдийн дийлэнх нь бүрэн бус болон бүрэн дунд боловсролтой байхад мөн насны эмэгтэйчүүдийн нэлээд хувь нь бүрэн дунд, тусгай дунд боловсролтой байна. Харин тусгай дунд, дээд боловсролтой хүн амд эмэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байгаа ба энэ нь сүүлийн үед эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол боловсрол эзэмших асуудалдаа илүү анхаарал тавьдгийг илэрхийлж байгаа юм. Мөн эцэг эхчүүд ч охиддоо боловсрол эзэмшүүлэх асуудалд илүү анхаарал тавьдаг, нөгөө талаар хөвгүүд охидыг бодвол эрт ажил хийж эцэг, эхдээ тусалж эхэлдэг зэрэгтэй холбоотой. Өнөөдөр боловсролд хүйсийн харьцаа алдагдаж байгаа, ялангуяа дээд боловсролтой хүн амд эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байгаа нь хэсэг хугацааны дараа нийгэм, гэр бүлийн хүрээнд тодорхой сөрөг нөлөө үзүүлэхийг үгүйсгэх аргагүй юм.

Эмэгтэйчүүд манай бараг бүх шатны сургуулийн багшлах боловсон хүчний дийлэнхийг эзэлдэг тул тэд боловсролын салбарын хөгжилд асар их үүрэг гүйцэтгэдэг. Ерөнхий боловсролын 100 багшийн 75 нь эмэгтэй, 100 захирал, дэд захирал, хичээлийн эрхлэгчийн 39 нь, мэргэжлийн боловсролын сургуулийн 100 ажиллагсдын 54 нь тус тус эмэгтэй байна.

Зураг 3: Ерөнхий боловсролын сургуульд ажиллагсдад 1996



Эрдэм шинжилгээний байгууллагад нийт ажиллагсдын 47,8% нь эмэгтэйчүүд байна. Эрдэм шинжилгээний удирдах ажилтны 10,8%, тэргүүлэх ажилтны 3,7%, ахлах ажилтны 22,3%, ажилтны 46,2%, дэд ажилтны 66,5%, туслах ажилтны 66,4%, техникийн ажилтны 54,9%, захиргаа аж ахуйн 55,5% нь тус тус эмэгтэйчүүд байна. (Шинжлэх ухааны байгууллагад ажиллагсдын тайлан, 1996)

Шилжилтийн үед манай улсад албан бус боловсролын тогтолцоо бүрдэж бий болох эхлэлийн шатандаа байгаа юм. Гэгээрлийн яам, Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо хамтран ЮНЕСКО-гийн тусламжтайгаар "Говийн малчин эмэгтэйчүүдийн сурах хэрэгцээг хангах албан бус боловсрол" төслийг 1994-1996 онд хэрэгжүүлж говийн 5 аймгийн 15,0 мянган эмэгтэйчүүдийг хамруулсан ба уг сургалт үр дүнтэй болж, өргөн уудам газар нутагт хүн ам нь таруу байрласан, бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг монголын малчин эмэгтэйчүүдийн боловсрол, амьдрах арга ухааны мэдлэг, соёлын түвшинг дээшлүүлэхэд тохиромжтой арга хэлбэр болох нь харагдсан юм.

1993 оноос Засгийн газраас "Монголын боловсрол, хүний хүчин зүйл" боловсролын хөгжлийн мастер төлөвлөгөөг Азийн хөгжлийн банкны тусалцаатайгаар мөн боловсролын хөгжлийн нэгдсэн бодлого, албан бус боловсролын үндэсний хөтөлбөрийг гарган хэрэгжүүлж байна. Түүнчлэн 1997-2000 онд боловсролын салбарт өөрчлөлтийн үндсэн чиглэл боловсруулан мөрдөж бүтцийн өөрчлөлт хийж байгаа юм. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах зорилгод хүрэх шилдэг арга замын нэг нь хүн ардынхаа албан ёсны болон албан бус боловсрол, мэргэжлийн бэлтгэлд хөрөнгө оруулалт хийх явдал гэж үзэж засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын санхүүжилтэд улсын төсвийн 20-оос доошгүй хувийг зориулахаар тусгасан бөгөөд 1998 онд улсын төсвийн 22 хувийг боловсролд зарцуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 3. Улсын төсвөөс боловсролын салбарт зарцуулсан зардал, 1991-1996						
Он	1991	1992	1993	1994	1995	1996
Хувь	22,9	26,5	15,6	16,2	15,7	17,2

Мэдээллийн эх сурвалж: Монголын нийгэм, эдийн засаг, 1996, УСГ

4. Удирдлага болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо

Эмэгтэйчүүдийн нийгмийн статус, тухайн орны соёл иргэншлийн онцлог, төрийн бодлогын шинж чанар, иргэний ардчиллын түвшинг харуулдаг нэг чухал үзүүлэлт нь удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаанд ялангуяа тэдгээрийн дээд түвшинд эмэгтэйчүүд хэрхэн оролцож байна вэ? гэдгээр тодорхойлогддог. Удирдлагад болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх нь ардчилал, нийгмийн шударга ёс, хөгжлийн зорилгод хүрэх нэг гол хүчин зүйл гэж үзэж, энэ хүчин зүйлийг ашиглан үр дүнд хүрч болохыг өндөр хөгжилтэй олон орны туршлага харуулж байна.

Монгол улсын иргэний шууд буюу төлөөлөгчийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох, төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг үндсэн хуулиар, төрийн албанд Монгол улсын иргэн тэгш эрх, адил нөхцөлөөр орох эрхтэй гэдгийг Төрийн албаны тухай хуулиар тус тус баталгаажуулсан учир удирдлагад болон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах хууль зүйн таатай орчин үндсэндээ бүрдсэн гэж үзэх үндэстэй юм.

Хүний эрх хуулиар хамгаалагдсан тэгш боломжийн иргэний нийгэмд нийгмийн амьдралын бүх хүрээнд идэвхтэй үүрэг хүлээх эмэгтэйчүүдийн эрх бололцоог хэн ч албан ёсоор хааж боодоггүй боловч жинхэнэ бодит амьдралд дээр байдал эрс өөр байдаг бөгөөд энэ бүгдийг тоо мэдээллээс харж болно.

Олон улсын жишигт удирдан дагуулах, бодлого боловсруулах, шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоо ямар байна гэдгийг тодорхойлохдоо:

- Төр засгийн удирдах дээд, дунд түвшинд
- Улс төр, Олон нийтийн байгууллагад
- Аж ахуй, бизнесийн үйл ажиллагаанд
- Өрх гэрийн хүрээнд гэсэн чиглэлээр түвшинг тооцож дүгнэлт өгдөг.

1992 оноос Үндсэн хуулийн засаглал хуваах ардчилсан зарчмаар байгуулагдсан төр засгийн 3 өндөрлөгт эмэгтэйчүүдийн оролцоо ямар байгааг дараах тоо баримтууд харуулж байна. Монгол улсад эмэгтэйчүүдийн боловсрол мэргэжлийн түвшин өндөр боловч улс төр, эдийн засаг, нийгмийн өндөр түвшинд төлөөлөл, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо өмнөх тогтолцооны үеийнхээс эрс буурчээ. Тухайлбал: 1992-1996 онд парламентын 76 гишүүний 3 нь буюу 3,9% нь эмэгтэйчүүд байсныг өмнөх тогтолцооны үеийн төрийн эрх барих дээд байгууллагад эмэгтэйчүүдийн эзэлж байсан хувьтай харьцуулбал 8 дахин буурч, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд эмэгтэйчүүд 9,0 хувийг эзэлж байсан нь мөн өмнөх үеэс 3 дахин цөөн байв. Улсын дээд

шүүхийн гишүүдийн 17,6% нь эмэгтэйчүүд, Засгийн газрын танхим, аймаг хотын засаг даргын нарын бүрэлдэхүүнд түүнчлэн Ерөнхийлөгчийн Тамгийн газарт нэг ч эмэгтэй байхгүй, Сайд нар, дээд шатны Засаг дарга, тэдгээрийн орлогч нь бүгд эрэгтэйчүүд байв.

- Одоогийн шинэ парламентийн (1996 оны сонгуулиар) 76 гишүүний 7 нь буюу 9,3% нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх парламенттэй харьцуулахад 2,3 дахин нэмэгдсэн бөгөөд үүнд эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын идэвхтэй оролцоо ихээхэн нөлөөлсөн юм. Харин Засгийн газрын гишүүд, яамдын төрийн нарийн бичгийн дарга, элчин сайд, аймгуудын засаг дарга, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга зэрэг өндөр албан тушаалд нэг ч эмэгтэй байхгүй, Яамдын газар, хэлтсийн дарга нарын 7,5% нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 4. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, 1997

		Нийт тоо	Эмэгтэйчүүд
1	Улсын их хурлын гишүүд	76	7
2	Засгийн газрын гишүүд	9	0
3	Төрийн нарийн бичгийн дарга	9	0
4	Аймаг, хот, сум, дүүргийн засаг дарга	373	9
5	Элчин сайд	28	0
6	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга	22	0

Засгийн газрын танхим ганц хүйсээс бүрдсэн, эдийн засгийн шийдвэр гаргах эрх, нөлөө бүхий УИХ-ын байнгын хорооны дарга, Сангийн сайд зэрэг албыг эрэгтэйчүүд хашиж байгаа, илломат төлөөлөгчдийн газрын эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөхөөр 26 хүн ажилладгийн 26,9% буюу 7 нь эмэгтэй байгаа нь эдийн засгийн шийдвэр гаргах төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөлөл доогуур байгааг харуулж байна.

Шигтгээ 5

Парламентад болон төр засгийн дээд удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг ойрын жилүүдэд 10% болгож, цаашид 20% хүртэл нэмэгдүүлэх зорилтыг тавьж, хөгжлийн төлөвлөлтийг хүн амын хүчин зүйлтэй уялдуулах, ялангуяа хүний нөөцийг бүрэн дүүрэн ашиглах зарчмыг баримтлан хүн ам ба тогтвортой хөгжлийн төрийн бодлогыг 1996 онд "Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлого", "Эмэгтэйчүүдийн аж байдлыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг баталсан юм.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд улс төрийн намууд тодорхой алхам хийх, эмэгтэйчүүдийг удирдах ажлын мэдлэг, чадавхи эзэмшихэд тал бүрээр дэмжих, сургаж бэлтгэх, эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагуудын хүчийг дайчлах зэрэг бололцоотой арга замыг үр дүнтэй ашиглахыг Засгийн газар зорьж байна. Парламентад суудалтай улс төрийн намуудын удирдах зөвлөлд эмэгтэйчүүд МАХН-д 10%, МҮАН-д 9,5%, МСН-д 6,6 хувийн төлөөлтэй байна.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу байгуулагдсан бүх шатны Засаг даргын ажлын албанд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн хувийн жинг харахад харьцангуй хангалттай мэт боловч энэ нь ихэвчлэн туслах болон үйлчлэх албаны хүмүүсийг хамтатган авч үзсэн тоо гэдгийг анхаарах хэрэгтэй. Ажил хөдөлмөр эрхэлж байгаа дээд, тусгай мэргэжлийн сэхээтний дунд зохих боловсролтой эмэгтэйчүүдийн нөөц байлаа ч бүх шатны сонгуульт ба томилолтын удирдах дээд албанд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байна.

- Төрийн захиргааны төв байгууллагад ажиллагсад буюу төрийн албан хаагчдын хүйсийн харьцаа ойролцоо (51 нь эмэгтэйчүүд) байгаа хэдий ч төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 10 дахин бага байна.
- Монгол улсын хэмжээнд 1994 онд 243 шүүгч ажиллаж байсны 53,1% нь эмэгтэй шүүгч байсан бол 1997 онд 325 шүүгч ажиллаж байгаагийн 163 буюу 50,1% нь эмэгтэйчүүд байна. Дээд шүүхийн гишүүдийн 17,6%, аймаг нийслэлийн шүүгчдийн 42%, сум дундын болон дүүргийн шүүгчдийн 63,8% нь эмэгтэйчүүд, Улаанбаатар хотын дүүргүүдийн эмэгтэй шүүгчдийн 9,7%, аймгуудын эмэгтэй шүүгчдийн 10,8% нь ерөнхий шүүгч байна. Шүүх эрх мэдлийн хувьд удирдлагын болон шийдвэр гаргах түвшин дээшлэх тутам эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин мөн л буурч байна.
- Хувийн Эздийн холбооны гишүүдийн бүртгэлээс үзэхэд 1992 онд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн 23,3% нь, 1996 онд 26,6% нь эмэгтэй эзэнтэй байв.
- 1996 онд олон нийтийн үүсгэл санаачлагын 584 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагийн 29 нь эмэгтэйчүүдийн хөдөлгөөн байна. Олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллагын 8,7% буюу 51 нь эмэгтэй тэргүүнтэй байна.

Улс төр, эдийн засгийн шийдвэр гаргах удирдлага, зохион байгуулалтын дээд түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо маш доогуур байгаа нь анхаарал татаж буй асуудлын нэг бөгөөд Монголын эмэгтэйчүүдийн боловсролын өндөр түвшинг нийгэм эдийн засгийн хөгжилд аль болох бүрэн дүүрэн ашиглах, хөгжил дэвшил дэхь эмэгтэйчүүдийн үүрэг оролцоог бодиттойгоор үнэлэх явдал төр засаг, ард түмний өмнө чухлаар тавигдаж байна.

5. Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хүний эрх

Хүний эрхийг зөрчиж буй нэг хэлбэр нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл юм. Монгол улс эмэгтэйчүүдийн байдлыг дээшлүүлэх бодлого, үйл ажиллагаандаа НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах Конвенц, Улс төрийн тэгш эрх болон эмэгтэйчүүдийн холбогдолтой бусад конвенцийн заалтууд, олон улсын хамтын нийгэмлэгээс дэвшүүлж байгаа зорилт, үзэл санааг өөрийн орны онцлогтой уялдуулан баяжуулж тусган хэрэгжүүлж байна.

Шийтгээ 6

Эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөнд халдсан, хуулиар эдлэх ёстой эрхээ эдлэхэд нь тэдэнд саад болсон, хориг тавьсан аливаа үйл ажиллагаа, эмэгтэйчүүдийн эсрэг гэмт үйлдлийг манай улсад Эрүүгийн болон Иргэний, Гэр бүлийн, Эрүүгийн байцаан шийтгэх зэрэг хуульд заасны дагуу зохих хариуцлага, шийтгэл оногдуулан шийтгэдэг зарчимтай.

Гэвч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн хэрэгжилтийг хянах механизм сул, эмэгтэйчүүдийн эрх зүйн мэдлэг хангалтгүйгээс хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадахгүй хохирох явдал амьдралд тохиолдсоор байна. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн энэ үед эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөнд халдах явдал багагүй гарч, нийгмийн анхаарал татсан сөрөг үзүүлэлт өсөх хандлагатай байна.

Манайд улсад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар судалгаа, албан ёсны тоо баримт хомс байгаа хэдий ч гэр бүлийн хүрээнд эмэгтэйчүүдийн эсрэг хүч хэрэглэх, сэтгэл санааны байнгын дарамтад оруулах, албан тушаалтны зүгээс бэлгийн харьцааны дарамт үзүүлэх, охид, эмэгтэйчүүд биеэ үнэлэх, түүнд зуучилж ашиг олох, охид, эмэгтэйчүүдийг хүчиндэх зэрэг хүчирхийллийн хэлбэрүүд тохиолдож байна. Хууль хяналтын байгууллагын судалгаанаас үзэхэд гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байна. Хүч хэрэглэсэн гэмт хэргийн эзлэх хувийн жин сүүлийн 10 жилд дунджаар 25.6 хувьд хүрчээ. Сүүлийн 3 жилд гарсан гэмт хэргийн 3 хувийг эмэгтэйчүүд үйлдсэн байв. Гэмт хэрэг үйлдсний улмаас амь насаа алдагсдын 23,2% нь эмэгтэйчүүд байна. Гэмт хэргийн улмаас хохирогч нь голдуу эмэгтэйчүүд хүүхдүүд байна. Зөвхөн эмэгтэй хүн хохирогч байдаг ноцтой гэмт хэрэг бол хүчингийн хэрэг юм. Бага насны хүүхдийг тэр дотроо дагавар болон төрсөн охиноо хүчиндсэн жигшүүрт хэргүүд ч гардаг боллоо. 1995 онд л гэхэд хүчингийн хэрэг өмнөх оныхоос 9,8 хувиар өссөн байна. Архидан согтуурах явдал хүч хэрэглэсэн гэмт хэргийн гол шалтгаан болж байгаа бөгөөд архидалт гэр бүл ахуйн хүрээнд их байгаа нь эмэгтэйчүүд хохирох нөгөө талаар тэд гэмт хэрэгт холбогдох нэг нөхцөл болж байна.

Шийтгээ 7

Эрх нь хөндөгдсөн, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд эрүүл мэнд, сэтгэл зүй, хууль эрхийн зөвлөгөө өгч туслах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх талаар эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд, цагдаа, шүүх хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа туршлага манайд бий.

Шинээр байгуулагдаад удаагүй байгаа Хүчирхийллийн эсрэг төв сүүлийн 2 жил идэвхтэй ажиллаж, эмэгтэйчүүдийн тусламж, зөвлөгөө авахаар ханддаг газрын нэг болоод байна. 1996 оны эцсийн байдлаар тус төв, түүний хамгаалах байранд хот, хөдөөгийн 90 шахам эмэгтэй, 80 хүүхэд ирж үйлчлүүлсэний дөрөвний нэг нь дээд боловсролтой, үлдсэн нь тусгай, дунд боловсролтой эмэгтэйчүүд байв. Тус төвөөс Хүн Амын Бодлого, Хөдөлмөрийн Яамтай 1995 онд хамтран 3000 хүний дунд явуулсан социологийн судалгаанд хамрагдагсдын 57.6% хувь нь эмэгтэйчүүд байсан ба тэдний 31.4% нь гэр бүлийн доторхи зөрчилтэй байдлаас болж сэтгэл

санааны дарамтанд байдаг гэжээ. Гэр бүлийн хүрээнд ил далд хэлбэрийн хүчирхийлэл нэмэгдэж байгаагийн гол шалтгаан нь хуулийн болон ёс суртахууны хэм хэмжээнд түүнийг эсэргүүцэх орчин бүрдэж чадахгүй байгаатай холбоотой юм. Гэр бүлийн хүрээнд гарч байгаа гэмт хэрэг хүчирхийллийн нэг онцлог нь тэр бүр ил тод байдаггүй нуун дарагдуулах, эцэст нь эмэгтэйчүүд хүүхдүүд хохирдог явдал юм. Манай улсад хохирогчийн талаар судалгаа бараг явагддаггүй гэж хэлж болно.

1995 онд шүүх эмнэлэгийн шинжилгээ, магадлагаа гаргуулсан хүмүүсийн 18.4% нь эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн эсрэг халдсан хэргүүд байлаа. Гадны хүчинд автсан, хүчирхийлэгдэн хохирсон эмэгтэйчүүдийн тохиолдлуудыг нарийвчлан авч үзэхэд 84,1% нь янз бүрийн шалтгаан, хэлбэрээр зодуулан гэмтэж эрүүл мэндийг хохироосон, хөдөлмөрийн чадварыг алдагдуулсан байхад 15,8% нь бэлэгсийн холбоотой асуудлыг тогтоолгох, бэлэгсийн хэлбэрээр хүчирхийлсэн асуудлаар магадлалгаа тогтоолгосон байна. Бэлгийн холбогдолтой хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг насны бүлгээр авч үзэхэд 12-17 буюу шилжилтийн болон өсвөр насны охидууд хамгийн өндөр (24,6%) хувьтай байв. Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хохироосон гэмтлийн холбоотой гэмт хэргийн шалтгаан, хэлбэрийг судалж үзэхэд нөхөр нь зодож гэмтэл учруулсан, сэтгэл санааны дарамтад оруулсан байдал хамгийн өндөр (28,9%) байна. Эрүүл мэндээр хохирч зодуулсан эмэгтэйчүүдийг ажил мэргэжлээр авч үзэхэд 39,1% нь ажилчин, 33,9% нь ажилгүй, 12,7% нь албан хаагч, 8,8% нь оюутан, сурагчид байв. ("Эмэгтэйчүүдийн хүчирхийлэл эсрэг" семинарын илтгэлээс, 1996)

Эмэгтэйчүүдийн дунд биеэ үнэлэх, гэмт хэрэг зөрчилд холбогдох явдал газар авч байгаагийн дээр гэр бүлийн хүчирхийлэл өсч улмаар гэр бүл салах, гэр орноосоо дайжих, эцэг эхийн хараа хяналтаас гарч гудамжинд амьдардаг хүүхдүүд олширч байгаа зэрэг нь шилжилтийн өнөө үед нийгмийн хурц асуудлуудын нэг болоод байна.

Энэ бүгдээс үзэхэд "Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай" конвенцид нэгдэн орсон манай орны хувьд эмэгтэйчүүдийг элдэв хэлбэрээр хүчирхийлэхийн эсрэг улам бүр идэвхтэй ажиллагаа явуулах шаардлагатай байгааг харуулж байна.

6. Эмэгтэйчүүдийн асуудлаархи үндэсний тогтолцоо

1990 оноос хойш манай улсад эмэгтэйчүүдийн асуудлаархи үндэсний тогтолцоо үндсээрээ өөрчлөгдөж, шинэчлэгдлээ. 1990 оноос өмнө Монголд эмэгтэйчүүдийн төр олон нийтийн байгууллагын шинжтэй нэг байгууллага байсан юм. Эмэгтэйчүүдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын өнөөгийн тогтолцоог авч үзвэл:

- Төрийн эрх барих дээд байгууллага Монгол Улсын Их Хуралд Нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх үүргийн хүрээнд эмэгтэйчүүдийн асуудал багтдаг бөгөөд УИХ-ын эмэгтэйчүүдийн парламентийн бүлэг байгуулагдан ажиллаж байна.
- Монгол улсын Засгийн газарт Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын Сайдын эрхлэх ажлын хүрээнд эмэгтэйчүүдийн асуудал орж, ЭМНХЯ-ны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газарт эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан ажилтан ажилладаг ба тус яаманд

эмэгтэйчүүдийн асуудал хариуцдаг хүмүүсээс бүрдсэн баг зохион байгуулагдан ажиллаж байна.

- Орон нутгийн засаг захиргааны түвшинд бүх 21 аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст эмэгтэйчүүд, залуучууд, гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан ажиллаж байна.
- ЭМНХЯ-ны харъяанд бодлого хэрэгжүүлэх ажлыг хариуцсан Залуучууд, гэр бүл, эмэгтэйчүүдийн газрыг 1996 онд байгуулан ажиллуулж байна.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэд Хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газар байгуулагдаж, Засаг даргын Тамгийн газарт бодлогын асуудал хариуцсан, түүнчлэн Засаг, захиргааны анхан шатны нэгж сум, хороодод хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан орон тооны ажилтнууд ажиллаж байна.
- 1996 оны эцсээр Засгийн газрын шийдвэрээр Монгол улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын Сайд тэргүүлсэн Эмэгтэйчүүдийн асуудлаархи үндэсний зөвлөлийг байгуулав. Зөвлөлийн бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүд, яамдын хариуцлагатай ажилтнууд, эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллага, хөдөлгөөн, олон нийт, аж ахуй, хувийн үйлдвэрийн эзэд, хоршооллын зэрэг байгууллагуудын төлөөлөгчид оржээ. Энэхүү зөвлөл нь Эмэгтэйчүүдийн асуудлаархи үндэсний зөвшилцлийн дээд байгууллага бөгөөд эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах үндэсний байгууллага юм.
- Монгол улсад ардчилал хөгжих явцад эмэгтэйчүүдийн улс төр, нийгмийн идэвх дээшилж, тэд эрх ашиг, сонирхлынхоо дагуу сайн дураараа байгууллага, хөдөлгөөнд эвлэлдэн нэгдэх үйл явц өрнөж байна. Одоогоор манайд эмэгтэйчүүдийн төрийн бус 30 шахам байгууллага, хөдөлгөөн үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр байгууллагууд нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхийг болон улс төрийн боловсрол, хууль эрх, амьдрах ухааны мэдлэгийг дээшлүүлэхэд туслах чиглэлээр янз бүрийн төслүүдийг хэрэгжүүлж, эмэгтэйчүүд, гэр бүлийн хүрээнд төрөл бүрийн сургалт явуулах, өрхийн орлого нэмэгдүүлэх, ажлын шинэ байр бий болгох, семинар ярилцлага зохион байгуулах, зөвлөгөө өгөх зэрэг олон талын үйл ажиллагаа зохион байгуулж байна. Үүгээрээ тэд төр засгийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд бодитой хувь нэмэр оруулж байгаа бөгөөд нөгөө талаас эмэгтэйчүүд, гэр бүлийн талаархи тулгамдсан, нийгмийн анхаарал татсан буюу цаг үеийн чухал асуудлаар Засгийн газарт шахалт үзүүлэх үйл ажиллагааг ч явуулж байна.

Үндэсний тогтолцоог бэхжүүлэхэд мэдээлэл, судалгаа чухал үүрэгтэй. Үндэсний статистикийн газрын мэдээллээр эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, нөхөн үржихүйн байдал, өвчлөл, нас баралт, хөдөлмөрийн нөөц, боловсрол, нийгмийн даатгал, халамжид хамрагдсан байдал, гэр бүл, хүүхдийн нийгмийн асуудал зэрэг 40 гаруй үзүүлэлт тогтмол гардаг. Гэвч энэ нь хүйсийн талаархи мэдээлэл, судалгааны орчин үеийн шаардлагыг хангаж чадахгүй байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн хөлсний ялгаа, зээл авалт, цалин мөнгөөр үнэлэгддэг хөдөлмөр хийгээд үнэлэгддэггүй гэр орны ажилд зарцуулж байгаа цагийн судалгаа, албан бус сектор болон хөдөө аж ахуйд ажиллагч эмэгтэйчүүдийн хөдөлмөр

эрхлэлтийн талаархи мэдээлэл зэрэг олон чухал үзүүлэлтүүд хүйсээр гарч чадахгүй байна.

Либераль Эмэгтэйчүүдийн Оюуны Сан, Нийгмийн зөвшил-Эмэгтэйчүүд Хөдөлгөөн, Хуульч Эмэгтэйчүүдийн Холбооны хамтын санаачлагаар 1996 онд байгуулагдсан Австрали улсын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр төсөл амжилттай хэрэгжүүлж байгаа Эмэгтэйчүүдийн Мэдээлэл Судалгааны Төв, Хүчирхийллийн Эсрэг Төвүүдээс зохиож буй судалгаа, шинжилгээний болон бусад ажлууд нь эмэгтэйчүүдийн сэтгэл санаанд нийцэж, төр, засгийн үйл ажиллагаанд дэм болж байна.

Ашигласан материал

1. "Монгол улсын хүн амын бичиг үсэг мэдлэг, боловсрол" 1997
2. "Монголын эдийн засаг, нийгэм 1996 онд" статистикийн эмхтгэл, 1997
3. "Монгол улсын хүн ам", УСГ, 1994
4. "Хүйсийн мэдээлэл" 1997, дугаар 2, ЭМСТ
5. "Хүн ам Хөгжил" ХАБХЯ, 1995
6. "Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр, 1996
7. "Монголын эмэгтэйчүүдийн 6-р их хурал", 1990
8. Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг" семинарын илтгэлүүд, 1996
9. Монгол Улсын Хүний Хөгжил" илтгэл, 1997